



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны **06** сарын **03** өдөр

Дугаар **11**

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

Нэг.Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1.1.Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг тогтвортой, тууштай хэрэгжүүлэх;

1.2.Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 39 дүгээр зүйлийн 39.12, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8 дугаар зүйлийн 8.6, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.10 дахь хэсэгт заасан журам, үлгэрчилсэн дүрэм, стандартыг боловсруулж, батлан мөрдөх;

1.3.Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж, боловсролын сургалтын байгууллагын эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглах, шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрын хэмжээг сургалт, судалгаа, туршилтын үйл ажиллагаа явуулах, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой байхаар тогтоож байх;

1.4.Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгыг нэн тэргүүнд тавьж, шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх, хувийн сургууль, цэцэрлэгийг байгуулахад Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д заасан зарчмын хүрээнд төрөөс зохих дэмжлэг үзүүлэх, өдөр өнжүүлэх үйлчилгээг зохицуулсан эрх зүйн орчныг бий болгох;

1.5.Малчдын 6 настай хүүхдэд боловсрол эзэмшүүлэхдээ амьдрах орчин, асран хамгаалах боломж нөхцөлийг бүрдүүлэх, ерөнхий боловсролын сургуульд анх элсэн орохдоо насны сонголттой байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

1.6.Үндэсний уламжлалаа хадгалсан ёс суртахуунтай хүүхэд, залуучуудыг төлөвшүүлэх чиглэлээр суурь боловсрол олгох сургалтын хөтөлбөрт Монгол Улсын түүх, өв соёл, эх хэл, ёс заншлын агуулгыг нэмэгдүүлэх, түүнд үнэлгээ хийх, шалгуур тогтоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

1.7.Зах зээлд худалдаалагдах хүүхдийн үлгэрийн, уран зохиолын болон бусад төрлийн номын агуулга, зураг, текстэд тавигдах шаардлага, стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бүрдүүлэх;

1.8.Шинэ орон сууцны хороолол, хотхон төлөвлөх, барьж байгуулахдаа сургууль, цэцэрлэгийг хамтад нь шийдвэрлэдэг байх эрх зүйн орчныг бүрдүүлж мөрдөх;

1.9.Хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгах.

Хоёр.Тогтоолын биелэлтийг 2015 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /Л.Гантөмөр/, Сангийн яам /Д.Эрдэнэбат/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /С.Эрдэнэ/, Эрүүл мэнд, спортын яам /Г.Шийлэгдамба/, Стандартчилал, хэмжил зүйн газар /Г.Гантөмөр/-т тус тус даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ